

МАНАЙ УЛСЫН КОМПАНИУДЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙГ ХЭМЖИЖ БҮЙ ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

А.Еркеш

Хураангуй

Монгол улсыг хамарсан томоохон судалгаануудын үр дүнгээр компаниудын инноваци, бүтээмж, ашигт ажиллагааны өнөөгийн байдалд хийсэн ерөнхий үнэлэлт, компаниуд өөрийнхөө үйл ажиллагааны гүйцэтгэлийг хэмжиж буй байдлыг судлан үзэж бизнесийн байгууллага нь үйл ажиллагааны гүйцэтгэлийг хэмжих шалгуур үзүүлэлтүүдийг зөв тодорхойлж, хэмжихгүй байгаа учраас түүнийг сайжруулж чадахгүй байна гэсэн дүгнэлтэнд хүрсэн. Иймд компаниуд үйл ажиллагааны гүйцэтгэлийг үнэлэхдээ Синк ба Туттлын 1989 онд тодорхойлсон гүйцэтгэлийг хэмжих 7 шалгуур үзүүлэлт, тэдгээрийн хоорондын уялдаа холбоо, компанийн нийгмийн хариуцлагын биелэлтийг хэмжих үзүүлэлтүүдийг цогц байдлаар тооцох нь ач холбогдолтой болохыг тодорхойлсон.

Цаашдаа аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны гүйцэтгэлийг харуулах шалгуур үзүүлэлтүүдэд шинжилгээ хийж, дүгнэлт гаргах үлгэрчилсэн аргачлалыг нийтлэг жишгээр боловсруулах шаардлагатай байна. Нийтлэг аргачлалтай болсон үед компани бүр уг нийтлэг аргачлалд нийцүүлэн өөрийн үйл ажиллагааны онцлог тохирсон гүйцэтгэлийг хэмжих системийг загварчилж, хөгжүүлэх боломжтой болно.

Abstract

The countrywide research on the overall assessment of current innovation, productivity and profitability of companies and the study of existing individual performance measurement system for business have concluded that business entities have not seen improvements in their performance due to the failure in defining performance indicators and their measurement system. Therefore it underscores the importance of business performance measurement if it is applied as inclusive including the 7 key performance criteria defined by Sink and Tuttle, their interrelationship and indicators of corporate social responsibility.

Further, it is required to develop common methodology on the analysis and conduct of conclusion of the criteria for business performance measurement. Upon the availability of such common methodology, it will be feasible for companies to individually design and develop its performance measurement system that is in parallel with the feature of operation.

Түлхүүр үгс

Гүйцэтгэлийг хэмжих шалгуур үзүүлэлтүүд, гүйцэтгэлийн хэмжилт, ашигт ажиллагаа, бүтээмж, инноваци, ажиллагсадын ажлаасаа авч буй сэтгэл ханамж, чанар, үр ашиг, үр өгөөж, компаний тогтвортой өсөлт хөгжил, компаний нийгмийн хариуцлага

I. Товч агуулга

Аж ахуйн нэгжийн гүйцэтгэлийг хэмжих систем нь түүний үйл ажиллагааны бүхий л түвшинд сайжруулалтыг бий болгоход чиглэнэ. Аж ахуйн нэгжийн гүйцэтгэлийг хэмжих сайн систем нь байгууллагын эрхэм зорилго, зорилтуудтай уялдах ба удирдлагыг зөв шийдвэр гаргахад туслана. Иймд компани бүр өөртөө тохирсон үйл ажиллагааны гүйцэтгэлийг хэмжих системийг загварчилж, хөгжүүлэх хэрэгтэй. Хэрэв үйл ажиллагааны гүйцэтгэлийг харуулах шалгуур үзүүлэлтүүдийг зөв тодорхойлж, хэмжиж чадахгүй бол үйл ажиллагааны гүйцэтгэлийг сайжруулж чадахгүй юм.

Бизнесийн үйл ажиллагааны эцсийн үр дүн ашигт ажиллагаагаар хэмжигдэнэ. Гэхдээ ашигт ажиллагаа өндөр байх нь сайн гэсэн дүгнэлт шууд өгч болохгүй. Бизнесийн байгууллагын ашигт ажиллагааны өсөлт болгон урт хугацааны тогтвортой өсөлтийг хангаж чадахгүй. Ажиллагсадын ажлаасаа авч буй сэтгэл ханамж, үр өгөөж, үр ашиг, бүтээгдэхүүн ба үйлчилгээний чанар, инноваци зэрэг үзүүлэлтүүдийн өсөлтийн үр дүнд бүтээмж нэмэгдэж, бүтээмжийн өсөлт ашигт ажиллагааны өсөлтийг бий болгож, компани нийгмийн хариуцлагаа бүрэн хэрэгжүүлж байгаа үед компани урт хугацаанд амжилттай оршин тогтоно.

Иймд би энэхүү судалгааны ажлаараа манай улсын компаниуд үйл ажиллагааны гүйцэтгэлийг хэмжиж байгаа өнөөгийн байдал судалгаа хийж, түүнийг сайжруулах талаар санал дэвшүүлэхийг зорьсон.

II. Судлагдсан байдал

Аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны гүйцэтгэлийг үнэлэх олон аргачлал, загвар дэлхийн улс орнуудад өргөн ашиглагдаж байна. Манай орны хувьд энэ асуудал онол арга зүйн хувьд яригдаж байгаа боловч практик хэрэглээ маш дутмаг байна. Аж ахуйн нэгжүүд үйл ажиллагааны гүйцэтгэлийг ихэвчлэн ашгийн үзүүлэлтээр хэмжиж, бүтээмж ашигт ажиллагаанд яаж нөлөөлж байгааг судлахгүй байгаа нь өрөөсгөл юм.

Монгол улсын хувьд судлагдсан байдлыг авч үзвэл энэ чиглэлээр хамгаалсан дараах эрдэм шинжилгээний бүтээлүүд байна.

- Л.Оюунцэцэг “Бүтээмжийн удирдлагыг боловсронгуй болгох нь: Хөнгөн үйлдвэрийн салбарын жишээн дээр” 1998

- он,
- О.Бат-Эрдэнэ “Монголын газар тариалангийн салбарын бүтээмжийг дээшлүүлэх зарим асуудал” 2001 он,
- М.Эрдэнэбаяр “Орц-гарцын шинжилгээний онол, арга зүйн зарим асуудал” 2004 он,
- Л.Батгэрэл “Инновацийг идэвхжүүлэн бүтээмжийг дээшлүүлэх арга зам” 2005 он гэх мэт.

III. Манай улсын компаниудын үйл ажиллагааны гүйцэтгэлийг хэмжиж буй өнөөгийн байдал

Дэлхийн улс орнуудын өрсөлдөх чадварыг хооронд нь харьцуулан бэлтгэдэг судалгааны тайланд манай улсын өрсөлдөх чадварын эрэмбэ дараах байдалтай байна.

Үүнд:

- ✓ Дэлхийн өрсөлдөх чадварын судалгааны төвийн тайланд Монгол улс 2015 оноос эхэлж орсон байна. 2015 онд Монгол улс судалгаанд хамрагдсан 61 орноос өрсөлдөх чадвараараа 57 дугаарт эрэмблэгдсэн байна.¹
- ✓ Дэлхийн эдийн засгийн форумын судалгаанд Монгол улс 2005 оноос хойш хамрагдсан бөгөөд 2014-2015 оны тайланд судалгаанд оролцсон 144 орноос өрсөлдөх чадвараараа 98 дугаарт, 2015-2016 оны тайланд 140 орноос 104 дүгээр байранд тус тус жагссан байна.²

Дээрх тайлангуудыг судалж үзэхэд манай улс өрсөлдөх чадвараа нэмэгдүүлэхийн тулд инноваци, бүтээмжийн сайн тогтолцоог бүрдүүлж, эдийн засаг, нийгмийн хөгжил шинэчлэлд түүний оруулах хувь нэмрийг дээшлүүлэх шаардлагатай болох нь харагдаж байна. Инновацийн хөгжил манай орны хувьд нилээн доогуур байна.³Энэ нь компаний бүтээмж доогуур байхад нөлөөлж байна. Компаниудын ашигт ажиллагаа ба бүтээмж доогуур байгаа нь манай улсын өрсөлдөх чадварт муугаар нөлөөлж байна.

⁴Компаниудын бүтээмж доогуур байгаа нь манай улсын эдийн засгийн хоцрогдлын үндсэн

1 <http://www.imd.org/wcc/news-wcy-ranking/IMD> World Competitiveness Rankings 2015

2 World Economic Forum: The Global Competitiveness Report 2014-2015, p13

World Economic Forum: The Global Competitiveness Report 2015-2016, p7

3 Монгол улсад үндэсний инновацийн тогтолцоог хөгжүүлэх хөтөлбөр /2008-2015 он/, р6-8

4 Mongolian Economic Policy and Competitiveness Research center: Mongolian Competitiveness Report 2013, p31

шалтгаан болж байгаа тул 2007-2017 онд хэрэгжүүлэх Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлогод бүтээмжийн үр ашигтай тогтолцоог бүрдүүлэх замаар эдийн засгийн эрчимтэй хөгжлийг бий болгох нь чухал болохыг тэмдэглэсэн.

Манай улсын хувьд Үндэсний статистикийн хороо макро эдийн засгийн статистик үзүүлэлтэд хамруулан эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар дараах бүтээмжийн үзүүлэлтүүдийг тооцож байна. Үүнд:

- ✓ Нийт бүтээмж
- ✓ Үндсэн хүчин зүйлийн бүтээмж
- ✓ Хөдөлмөрийн бүтээмж
- ✓ Үндсэн капиталын бүтээмж
- ✓ Үндсэн түүхий эд материалын бүтээмж
- ✓ Эрчим хүчний бүтээмж

Эдгээр бүтээмжийн үзүүлэлтүүдийг тооцоход Үндэсний статистикийн хорооноос баталсан “Бүтээмжийн үзүүлэлтүүдийг зэрэгцүүлсэн үнээр тооцох аргачлал”-ыг мөрдөнө.⁵

Аж ахуйн нэгж, байгууллагууд санхүүгийн тайланд шинжилгээ хийхэд “Аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайланд шинжилгээ хийх үлгэрчилсэн аргачлал”-ыг мөрдөнө.⁶ Уг аргачлалд зааснаар бүтээмжийн шинжилгээг хийхэд дараах үзүүлэлтүүдийг тооцно.

Үүнд:

- ✓ Хөдөлмөрийн бүтээмж
- ✓ Үндсэн хөрөнгийн ачаалал
- ✓ Материалын өгөмж
- ✓ Эдийн засгийн тогтвортой өсөлтийн коэффициент

Өнөөдрийн байдлаар дээрх 2 аргачлалаас өөр манай улсад макро, микро аль ч түвшинд бүтээмжийг хэмжих, удирдахад баримтлах нэгдсэн аргачлал байхгүй байна.

“Бүтээмжийн үзүүлэлтүүдийг зэрэгцүүлсэн үнээр тооцох аргачлал”-ыг баримтлан нийт эдийн засгийн түвшинд болон эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар бүтээмжийг хэмжихэд хангалттай хэдий ч “Аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайланд шинжилгээ хийх үлгэрчилсэн аргачлал”-ын дагуу аж ахуйн нэгжийн бүтээмжийг хэмжих, үнэлэх нь

хангалтгүй юм.

2015 оны 9 дүгээр сарын мэдээгээр Монгол улсад нийт 152,248 хуулийн этгээд улсын бүртгэлд бүртгэгдсэн байгаагаас 295 нь хувьцаат компани, 102,066 нь хязгаарлагдмал хариуцлагатай компани, 88 нь төрийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар, 352 нь орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар, үлдсэн нь бусад хэлбэрээр зохион байгуулагдсан хуулийн этгээд байсан.⁷ Статистикийн мэдээнээс үзэхэд нийт аж ахуйн нэгжийн 52 орчим хувь нь үйл ажиллагаагаа хэвийн явуулж байна. Санамсаргүй сонголтоор үйл ажиллагаа нь хэвийн явагдаж байгаа 10 хувьцаат компани, 10 төрийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрыг сонгон авч үйл ажиллагааны гүйцэтгэлийг яаж үнэлж байгааг судалж үзсэн. Эдгээр компаниуд үйл ажиллагааны гүйцэтгэлийг ерөнхийдөө төсөв төлөвлөгөөний биелэлт, ашигт ажиллагааны үзүүлэлтүүдээр хэмжиж байсан.

Практикт аж ахуйн нэгжүүд дотооддоо ашигт ажиллагаа, бүтээмжийн зарим үзүүлэлтүүдийг тооцож ашиглаж байгаа хэдий ч эдгээр нь үйл ажиллагааны гүйцэтгэлийг үнэлэхэд хангалтгүй байна. Мөн аж ахуйн нэгжүүдээс авсан судалгаагаар аж ахуйн нэгжүүд бүтээмжийн ашигт ажиллагаанд үзүүлж буй нөлөөлөл, компани нийгмийн хариуцлагаа бүрэн хэрэгжүүлж чадаж байгаа эсэхийг хэмжиж үнэлэхгүй байгаа нь харагдсан.

Манай аж ахуйн нэгжүүдийн хувьд хамгийн цэгцтэй, үнэн зөв, хугацааны тодорхой үеэр тогтмол бэлтгэгддэг мэдээлэл нь нягтлан бодох бүртгэлийн мэдээлэл байдаг. Аж ахуйн нэгжүүд “Нягтлан бодох бүртгэлийн дансны жишиг жагсаалт”⁸-ын дагуу дансны төлөвлөгөөгөө зохион нягтлан бодох бүртгэлийг хөтөлж байна. Аж ахуйн нэгжүүдийн дансны төлөвлөгөө нь бүтээмж, ашигт ажиллагааны үзүүлэлтүүдийг тооцоход зориулж зохион байгуулагдаагүй байгаа нь эдгээр үзүүлэлтүүдийг тооцоход шаардлагатай мэдээллийг цуглуулахад цаг хугацаа их зарцуулахад хүргэнэ.

7 <http://burtgel.gov.mn>/хуулийн этгээдийн улсын бүртгэлийн 2015 оны 9 дүгээр сарын мэдээ

8 Сангийн сайдын 2014 оны 249 тоот тушаалын 2 хавсралт

5 Үндэсний Статистикийн хорооны даргын 2010 оны 01/74 тушаалын хавсралт

6 Сангийн сайдын 2013 оны 277 тоот тушаалын хавсралт

IV. Аж ахуйн нэгжийн гүйцэтгэлийг хэмжих шалгуур үзүүлэлтүүд, тэдгээрийн хоорондын харилцан уялдаа

Аж ахуйн нэгж урт хугацаанд тогтвортой оршин тогтнох нэг үндэс нь үйл ажиллагааныхаа гүйцэтгэлийг зөв үнэлэх явдал юм. Дэлхийн улс орнуудын практикт аж ахуйн нэгжийн гүйцэтгэлийг хэмжих дараах аргуудыг түгээмэл ашиглаж байна. Үүнд:

1. Үйлдэлд суурилсан систем (Activity based Costing system)
2. Синк ба Туттлын загвар (Sink and Tuttle model)
3. Тэнцвэрт онооны хүснэгт (Balance Scorecard)
4. Гүйцэтгэлийн пирамид (Performance Pyramid)
5. Гүйцэтгэлийн призм (Performance Prism)
6. Хязгаарлалтын онол (Theory of constraints)
7. Медори ба Стееплийн загвар (Medori and Steeple's framework)
8. Малколм Валдриджийн загвар (Malcolm Baldrige model)
9. EFQM загвар (European Foundation for Quality Management-EFQM) гэх мэт.

Дээрх аргуудаас Balanced Scorecard, Malcolm Baldrige model, Performance Prism, EFQM загвар нь инновацийн гүйцэтгэлийг хэмжихэд ашиглагддаг чухал гүйцэтгэлийг хэмжих загварууд юм.⁹

Синк ба Туттлын 1989 онд танилцуулсан аж ахуйн нэгжийн гүйцэтгэлийг хэмжих 7 шалгуур үзүүлэлт, тэдгээрийн хоорондын харилцан хамаарлыг харуулсан загварыг ашиглаж бүтээмжийн өсөлт нь ашигт ажиллагааны өсөлтийг бий болгож байгаа эсэхийг үнэлж болно.

Синк ба Туттлын загварт аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны гүйцэтгэлийг үнэлэх дараах 7 шалгуур үзүүлэлтийн харилцан уялдааг авч үздэг. Үүнд:

1. Ашигт ажиллагаа (profitability)
2. Бүтээмж (productivity)
3. Инноваци (innovation/
4. Ажиллагсадын ажлаасаа авч буй сэтгэл

⁹ Cristian –Ionut Ivanov, Silvia Avasilcai (2013) "Performance measurement models: an analysis for measuring innovation processes performance", 12th International Symposium in Management

- ханамж (quality of work life)
5. Чанар (quality)
6. Үр ашиг (efficiency)
7. Үр өгөөж (effectiveness)

Эдгээр нь хоорондоо харилцан уялдаатай боловч ялгаатай ойлголтууд юм.

Ашигт ажиллагаа

Ашигт ажиллагаа нь компанийн ашиг олох чадварыг харуулна. Аж ахуйн нэгж боломжит бага нөөц зарцуулан ашигаа нэмэгдүүлэхийг эрмэлзэж байдаг. Ашигт ажиллагааны түвшинг харуулах дараах үзүүлэлтүүд байдаг.

1. Бүтээгдэхүүний ашиг олох чадвар
2. Оруулсан хөрөнгө, капиталын ашиг олох чадвар

Бүтээгдэхүүний ашиг олох чадвар нь борлуулалтын орлогын эсвэл борлуулсан бараа, бүтээгдэхүүний өртгийн нэг төгрөг тутмаас олж буй ашгийн хэмжээг харуулна. Оруулсан хөрөнгө ба капиталын ашиг олох чадвар нь хөрөнгө, капиталын нэгж тутмаас олж буй ашгийн хэмжээг харуулна.

Бүтээмж

Бүтээмж нь хөдөлмөр, капитал, газар, байгалийн баялаг, цахилгаан эрчим хүч, мэдээлэл, удирдан зохион байгуулах үр чадвар, хугацаа гэх мэт бүх төрлийн нөөцүүд хэр сайн ашиглагдаж байгааг илэрхийлэх үзүүлэлт юм. Бүтээмж нь орцын нэгжид ногдох гарцаар тодорхойлогдоно. Гарцыг үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн, үзүүлсэн үйлчилгээний тоо хэмжээ, үйлдвэрлэлийн өртөг, нэмэгдсэн өртгөөр хэмжинэ. Орцыг хөдөлмөр, капитал, бусад орцоор хэмжинэ.

Инноваци

Инноваци гэж эрдэм шинжилгээний ажлын үр дүнг эцсийн бүтээгдэхүүн болгон зах зээл, үйлдвэрлэл, үйлчилгээнд нэвтрүүлэх цогц үйл ажиллагааг хэлнэ.

Ажиллагсадын ажлаасаа авч буй сэтгэл ханамж

Ажиллагсад ажилдаа дуртай байвал ажлаасаа авч буй сэтгэл ханамж өндөр байна. Ажиллагсадын сэтгэл ханамжид нөлөөлөх хүчин зүйлсэд ажил үүргийн хуваарь, ажиллах орчин (материаллаг хангамж, хамт олны

Манай улсын компаниудын үйл ажиллагааны гүйцэтгэлийг хэмжиж буй өнөөгийн байдал

төлөвшил), удирдлагын систем, ажиллагсадын авч буй цалин хөлс нь хувийн амьдралыг нь хэрхэн хангаж байна зэрэг орно.

Чанар

Тухайн бүтээгдэхүүн, үйлчилгээ нь түүнд тавигдах стандартыг бүрэн хангаж байвал чанартай гэж үзнэ.

Үр ашиг

Хөдөлмөр, капитал, цаг хугацаа, цахилгаан,

дулаан гэх мэт бүх төрлийн нөөцийг боломжит бага хэмжээнд зарцуулан үйлдвэрлэл явуулахыг хэлнэ. Хаягдал, гологдол, хорогдлыг бууруулах замаар үр ашгийг нэмэгдүүлж болно. Үр ашгийг гарц ба орцын харьцаагаар хэмжих ба орцыг хамгийн бага гарцыг хамгийн өндөр байлгахад анхаардаг. Бүтээмж ба үр ашиг нь төсөөтэй боловч нарийн ялгаатай юм. Бид үйлдвэрийн хорогдол, гологдол өндөр байсан ч гэсэн гарцыг нэмэгдүүлэх замаар бүтээмжийг нэмэгдүүлж болно. Үр ашигтай байхын тулд


хаягдал, гологдол гэх мэт үргүй зардлыг бууруулах хэрэгтэй.

Үр ашиг ба үр өгөөж нь мөн адил төсөөтэй боловч нарийн ялгаатай ойлголт юм. Үр ашигтай байхын тулд үйл ажиллагаанд анхаарах хэрэгтэй байдаг бол үр өгөөжтэй байхын тулд ажлын үр дүнд анхаарна.

Үр өгөөж

Үр өгөөжтэй байна гэдэг нь үйлдвэрлэлд юу зарцуулах нь чухал биш юмыг сайн хийхийг хэлнэ. Үр өгөөж нь зорилгодоо хэр сайн хүрсэн бэ гэдгээс хамаарна. Жишээ нь хэдийгээр бүх компаниуд ашгаа нэмэгдүүлэхийг эрмэлзэж байдаг ч гэсэн зарим компаниуд богино хугацаанд ашгийг бууруулдаг ч гэсэн зах зээлээ өргөжүүлэх шийдвэр гаргаж болно. Энэ тохиолдолд компани нь үр өгөөжийг ашгийн өсөлтөөр биш зах зээлийн тэлэлтээр хэмжинэ. Үр өгөөжийг бодит гарцыг хүсэж буй гарцтай харьцуулах замаар хэмждэг. Үр өгөөжтэй байх нь үр ашигтай байхаас илүү сайн. Иймд аж ахуйн нэгжийг амжилттай эрхлэхийн тулд энэ 2 үзүүлэлтийн зохистой харьцааг хангах хэрэгтэй.

Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтүүдийн харилцан уялдаа



Зураг 1: Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтүүдийн харилцан уялдаа холбооны бүдүүвч (Синк ба Туттлын загвар, 1989)

Манай улсын компаниудын үйл ажиллагааны гүйцэтгэлийг хэмжиж буй өнөөгийн байдал

Энэ загварт тодорхойлсноор үр өгөөж, үр ашиг, чанар, ажиллагсадын ажлаасаа авч буй сэтгэл ханамж, инноваци нь тогтвортой нэмэгдсэн үед бүтээмжийн тогтвортой өсөлт бий болно. Бүтээмжийн тогтвортой өсөлт нь ашигт ажиллагааг нэмэгдүүлж байгаа тохиолдолд ашигт ажиллагааны өсөлт нь урт хугацааны тогтвортой өсөлтийг хангана.

Орчин үед дээрх загварт компаний нийгмийн хариуцлага гэсэн шалгуур үзүүлэлтийг нэмж дараах байдлаар тодорхойлох нь зүйтэй юм. Үр өгөөж, үр ашиг, чанар, ажиллагсадын ажлаасаа авч буй сэтгэл ханамж, инноваци нь тогтвортой нэмэгдсэн үед бүтээмжийн тогтвортой өсөлт бий болно. Бүтээмжийн

тогтвортой өсөлт нь ашигт ажиллагааг нэмэгдүүлж, компани нийгмийн хариуцлага бүрэн хэрэгжүүлж байгаа үед урт хугацаанд амжилттай оршин тогтоно. Компаний нийгмийн хариуцлага нь бүтээгч хүн, байгаль орчин, баялаг гэсэн 3 үндсэн асуудлын тэнцвэрт байдлыг хангаж байх ёстой. Бизнес нь хүний эрүүл мэнд, байгаль орчинд сөргөөр нөлөөлөхгүй, нийгэмд сөрөг үр дагавар авчирдаггүй, мөн хамтрагч, түншүүд, олон нийт, хэрэглэгч, ажиллагсадынхаа өмнө хүлээх хариуцлага, чиг хандлага нээлттэй тодорхойлсон, ил тод үйл ажиллагаа бүхий компанийг нийгмийн хариуцлагатай компани гэнэ.

Бүтээмж ба ашигт ажиллагааны хоорондын уялдааг дараах байдлаар тодорхойлж болно:

Нөхцөл	Бүтээмжийн түвшин	Ашигт ажиллагааны түвшин	Санхүүгийн шинжээчийн өгөх дүгнэлт	Цаашдаа юу хийх хэрэгтэй болох талаар удирдлагын гаргах шийдвэр
1	өндөр	өндөр	Компанийн санхүүгийн байдал найдвартай	Бүтээмжийн хүрсэн түвшинг хадгалах эсвэл үргэлжлүүлэн сайжруулах
2	доогуур	өндөр	Өндөр ашигт ажиллагаа удаан хугацаанд хадгалагдахгүй	Бүтээмжийг нэмэгдүүлэх
3***	өндөр	доогуур	Тухайн компани удалгүй алдагдалтай ажиллаж эхэлнэ	Зах зээл судлал идэвхжүүлэлт, үнийн бодлогоо сайжруулах, шинэ зах зээлд нэвтрэх замаар ашигт ажиллагааг нэмэгдүүлэх
4	доогуур	доогуур	Үйл ажиллагааг зогсоох /дампуурах/	Бүтээмж, ашигт ажиллагааг зэрэг нэмэгдүүлэх

Зураг 2: Бүтээмж ба ашигт ажиллагааны хоорондын уялдаа холбоо

***-Бүтээмжийн түвшин өндөр байгаагаас үл хамааран ашигт ажиллагаа доогуур байгаа нь зах зээл аль хэдийн ханасан, бүтээгдэхүүний борлуулалтын үнэ өндөр, эсвэл бүтээгдэхүүн зах зээлийн хэрэгцээ шаардлагыг хангахгүй байгаа гэх мэттэй холбоотой байж болно.

V. Дүгнэлт, санал

Манай улсын компаниудын үйл ажиллагааны гүйцэтгэлийг хэмжиж буй өнөөгийн байдалд судалгаа хийж дараах дүгнэлтэд хүрлээ:

1. Манай улсад одоогийн байдлаар аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны гүйцэтгэлд иж бүрэн шинжилгээ хийж, дүгнэлт гаргахад удирдамж болох аргачлал байхгүй байна.

2. Аж ахуйн нэгжүүд үйл ажиллагааны эцсийн үр дүнг зөвхөн ашгаар хэмжиж, ашгийн өсөлт нь компаний тогтвортой өсөлт хөгжлийг бий болгох эсэхийг үнэлэхгүй байна. Мөн аж ахуйн нэгжүүд үйл ажиллагааны гүйцэтгэлд шинжилгээ хийх явцад ашигт ажиллагаанд нөлөөлж буй бүтээмжийн нөлөөллийг тооцохгүй байна. Компаниуд үйл ажиллагааны гүйцэтгэлийг

зөв хэмжиж чадахгүй байгаа учраас түүнийг сайжруулж чадахгүй байна. Энэ нь компаниудын бүтээмж, ашигт ажиллагаа доогуур байх, улмаар манай улсын өрсөлдөх чадвар доогуур байхад нөлөөлж байна.

Дээрх дүгнэлтэнд үндэслэн дараах саналыг дэвшүүлж байна:

1. Аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны гүйцэтгэлд шинжилгээ хийж, дүгнэлт гаргах үлгэрчилсэн аргачлалыг нийтлэг жишгээр боловсруулах шаардлагатай байна. Үг аргачлалд үйл ажиллагааны гүйцэтгэлийг үнэлэх шалгуур үзүүлэлтүүдийн систем, тэдгээрийн харилцан уялдаа холбоог хэрхэн тооцож үнэлэлт өгөх, аж ахуйн нэгжүүд үйл ажиллагааны гүйцэтгэлийг түргэн шуурхай хэмжихэд тус дөхөм болохуйцаар нягтлан бодох бүртгэлийг яаж зохион байгуулах талаар дэлгэрэнгүй оруулах нь зүйтэй.
2. Аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны гүйцэтгэлийг үнэлэх шалгуур үзүүлэлтүүдийн системд үр өгөөж, үр ашиг, чанар, ажиллагсадын ажлаасаа авч буй сэтгэл ханамж, инноваци, бүтээмж, ашигт ажиллагаа, компаний нийгмийн хариуцлагыг хэмжих үзүүлэлтүүдийн системийг зайлшгүй оруулах нь зүйтэй юм.
3. Аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны гүйцэтгэлд шинжилгээ хийж, дүгнэлт гаргах нийтлэг аргачлалтай болсон үед компани бүр уг нийтлэг аргачлалд нийцүүлэн өөрийн үйл ажиллагааны онцлог тохирсон гүйцэтгэлийг хэмжих системийг загварчилж, хөгжүүлэх хэрэгтэй.

Ашигласан материал

1. Suwansaranyu. U, Phusavat. K (2002)“Understanding of Performance Measurement from the Organization’s Perspective”, 51-57, In Proceedings of Symposium in Production and Quality Engineering ,Kasetsart University, Bangkok, Thailand.
2. Maartens.W,(2008) “Efficiency and Effectiveness = Productivity”http://www.authorsden.com/categories/article_top.asp?catid=5&id=31506
3. Singhtaun.C,Phusavat.K (2004)“Impacts Productivity on Profitability for Organizational Performance Analysis”,
4. Najam-ul-Arifeen, Muddasir Hussain, Shazia Kazmir, Muhammad Mubin, Sumra Latif, Waqar Qadri (2014) “Measuring Business Performance: Comparison of Financial, Non financial and Qualitative Indicators”, European Journal of Business and Management, Vol6, No4.
5. Cristian –Ionut Ivanov, Silvia Avasilcai (2013) “Performance measurement models: an analysis for measuring innovation processes performance”, 12th International Symposium in Management
6. The Global Innovation Index 2015. Effective innovation Policies for Development, Johnson Cornell University, Insead: The Business School for the World, World Intellectual Property Organization
7. [IMD World Competitiveness Rankings 2015](http://www.imd.org/wcc/news-wcy-ranking/IMD_World_Competitiveness_Rankings_2015) [http://www.imd.org/wcc/news-wcy-ranking/IMD World Competitiveness Rankings 2015](http://www.imd.org/wcc/news-wcy-ranking/IMD_World_Competitiveness_Rankings_2015)
8. World Economic Forum: The Global Competitiveness Report 2014-2015, 13-14
9. Mongolian Economic Policy and Competitiveness Research center: Mongolian Competitiveness Report 2013, 31-32
10. Монгол улсад үндэсний инновацийн тогтолцоог хөгжүүлэх хөтөлбөр /2008-2015 он/, 6-8
11. Үндэсний Статистикийн хорооны даргын 2010 оны 01/74 тушаалын хавсралт “Бүтээмжийн үзүүлэлтүүдийг зэрэгцүүлсэн үнээр тооцох аргачлал”
12. Сангийн сайдын 2013 оны 277 тоот тушаалын хавсралт“Аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайланд шинжилгээ хийх үлгэрчилсэн аргачлал”-